

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ

ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БИЧИГ

№20/524

ШУС, НУС

2019

МАНЖ ЧИНГИЙН СҮҮЛЧ ҮЕИЙН МОНГОЛ СОНИН, СЭТГҮҮЛ ХИЙГЭЭД ТҮҮНИЙ СУРТАЛ УХУУЛГА

Оюун*

*Өвөр Монголын Их Сургуулийн доктор (Ph.D), профессор

Түлхүүр үг: монгол сонин сэтгүүл, суртал ухуулга

1 636 онд “Манж Монгол төрөө нэгтгэсэн”-ээс эхлэн 1691 онд Ар Монгол Манжийн хараат болж, 1771 онд ижил, зайгийн Торгууд Манж Чин улсад “эээр орж ирсэн”-ээс бүхий л монгол угсаатан Манж Чин улсын ноёрхолд орж Монгол орон их төлөв говийн өмнөх Монгол, говийн хойнох ар Монгол, тэнгэр уулын ар өврийн Өөлд Монгол гэх гурван хэсэг болсон юм. 19-р зууны сүүлч болоход Манж Чин улсад удаан жил дарлагдсан Монгол орон ядуу хоцронгийн туйлд тулсан байлаа. Энэ цаг үед хаант Орос “Дорнод хязгаарын амьдрал”, “Монголын сонин бичиг” хэмээх сонин бичиг эрхэлж алс Дорнотын бодлогодоо яриа хэлэлцээр зохиосон юм. Манж Чингийн засгийн газар хаант Оросын энэхүү ажиллагааны хариуд “Монгол үгийн бодрол” сэтгүүл эрхэлж Манжийн хааны “өршөөл”-ийг суртачлан ухуулж монголчуудад “Улс гүрний үзэл”-ийг бий болгох зорилт тавьжээ. Монголын сэхээрсэн Ван гүн монгол ардынхаа цэцэн ухааныг нээж, үндэстнээ мандуулах зорилгоор “Гарагийн албан сэтгүүл”, “Нялх сэтгүүл” зэрэг сонин хэвлэлийг эрхэлсэн юм¹.

Нэг. Монгол сонин сэтгүүл бий болсон түүхэн ахуй байдал

19-р зууны сүүлч 20-р зууны эхэн болоход Орос, Япон, Герман, Франц, Англи зэрэг хөгжсөн улсууд Манж Чин улсад банк байгуулах, албадлагаар зоос зээлүүлэх, төмөр замд хөрөнгө оруулах, уурхай гаргаж үйлдвэр байгуулах хэлбэрээр түрэмгийллээ чангатахын дагуу Манж Чингийн газар нутгыг албадан түрээсэлсэн буюу хэсэгчлэн эзэлсэн байна. Иймэрхүү хэсэглэн хуваалцах урсгал дунд хаант Орос болон Япон эрхшээлийн хүчнээ Монгол оронд эхлүүлжээ. Тэд монгол хошуудын уурхайг ухаж эх баялагийг тонож, Монголын Ван гүн нарыг өдөөн хатгаж Манж Чин улсаас салгахаар оролдож байсан юм. Хаант Орос Монгол оронд иймэрхүү улс төрийн эзэгнэл, аж ахуйн дээрэмдэлт явуулах явцад “Дорнод хязгаарын амьдрал”, “Монголын сонин бичиг” хэмээх сонин хэвлэлүүдийг эрхэлж, түрэмгийлэх ажилтайгаа хамжилцаж, яриа хэлэлцээр зохион монголчуудыг өдөөн татаж өөрийн нөлөөндөө оруулах суртал ухуулгын ажлыг эрчимтэй хийжээ. Манж Чин улс хаант Оросын энэхүү ажиллагаанд чиглүүлж “Монгол үгийн бодрол” сэтгүүл эрхэлж түүгээр дамжуулан монголчуудад улс гүрний ухамсрыг бий болгон, улмаар Оросын Монгол орон

дахь нөлөөг өргөжихийг хориглох ба Монгол орон дахь өөрийн эрх мэдлээ батлах зорилт тавьсан байна.

1901 оны нэгдүгээр сард Манж Чингийн засгийн газраас “Хууль өөрчлөх” зарлиг буулгаж, шинэ цэргийг байгуулан боловсруулах гааль татварыг нэмэгдүүлэх, арилжаа худалдааг өргөжүүлэх, сургууль байгуулж сурган хүмүүжүүлэх ухааныг дэлгэрүүлэхийг зорьсон “шинэ засаг”-ийг бүх улсын хэмжээнд хэрэгжүүлжээ. 1902 онд Монгол оронд “Иргэдийг нүүлгэх хязгаарыг бататгах” төрийн бодлого хэрэгжүүлэхээр Бадруулт төр хаан зарлиг буулгажээ. Ингээд Монгол оронд хятад иргэдийг нүүлгэн их хэмжээгээр газар тариалан эрхлүүлсэн бөгөөд хятад иргэд төвлөрөн суурьшсан газарт фү, тин, жөү, шянь байгуулснаар хятад тариачид олноор Монгол оронд нүүдлэн иржээ. Гадаадын түрэмгийлэл, дотоодын мөлжлөг нь монголчуудын ядууран хоосорч, мунхран доройтсон байдалд хэсэг сэхээрсэн Ван гүн ардынхаа ухаан бодлыг тэлж, аж ахуйгаа хөгжүүлж үндэстнээ мандуулах, монголчуудаа соён гэгээрүүлэхийн төлөө “Гарагийн албан сэтгүүл”, “Нялх сэтгүүл” хэмээх сониныг эрхлэн хэвлүүлсэн байна.

Манж Чин улсын сүүлчийн хугацаанд Монгол оронд “Шинэ засаг”-ийн бодлогыг хэрэгжүүлэхийн зэрэгцээ, Монголын Ван гүн засаг болон сэхээрэгсэд үйлдвэр худалдаа эрхлэн аж ахуйгаа хөгжүүлж, шинэ сургууль байгуулан “Ардын мэдлийг нээж” сонин сэтгүүл эрхлэн үндэстэн ардаа гэгээрүүлэх зорилт тавьжээ. Хаант Оросын Монгол орон дахь суртал ухуулга ба дайралтыг аргацаахын төлөө Манж Чин улс сонин сэтгүүл эрхлэн суртал ухуулга хийж, Монгол орон дахь ноёрхолоо чангатгаж

эхэлжээ. “Шинэ засаг”-ийн хэрэгжүүлснийг дагаад Монгол орон дахь тариалан аж ахуй ба худалдаа арилжаа улам ихээр хөгжиж, улмаар зам тээвэр, харилцаа холбоо хөгжжээ. 1890-ээд оны дунд үед монгол хорголжин үсгийн хэвлэл нь Орос улсын эрхэлсэн сонин сэтгүүлд анхлан гарч 20-р зууны 20-иод оноос Монголчуудын дунд аажимдаа хэрэглэгдэх болжээ. Монгол сонин, сэтгүүл нь улс төр, аж ахуй, сурган хүмүүжүүлэх ухаан ба техник мэргэжлийн түүхэн нөхцөлд ялангуяа улс үндэстэн доройтон мөхөх аюул түгшүүрт байдал зэрэг эдгээр хүчин зүйлээс шалтгаалан бий болжээ.

Хоёр. Манж Чингийн сүүлч үеийн монгол сонин сэтгүүлүүд

1. Хаант Оросын эрхэлсэн “Дорнод хязгаарын амьдрал”, “Монголын сонин бичиг”

17-р зуунаас эхэлсэн хаант Орос нь Хятад улсруу түрэмгийлж Монгол орны тэдний хүчинд автуулах гэсэн үйл ажиллагаанд 19-р зууны сүүлчээс хойш улам идэвхжиж эхэлжээ. Энэхүү улс төрийн бодлого ба үйл ажиллагаандаа яриа хэлэлцээр хийхийн төлөө хаант Оросын төлөөний хүн буриад монгол Бадмаев² гэгч 1995 онд Оросын Чита хотод “Дорнод хязгаарын амьдрал” сониныг эрхэлжээ. Энэхүү сониныг эрхэлсэн явдал бол Бадмаевийн төлөвлөгөө³-ний нэг мөн. Энэ сонин 1895 оны сүүлчээс 1897 оны зургаадугаар сар хүртэл хоргилжин бараар орос, монгол хэлээр нийт 450 дугаар хэвлэгджээ. Эл Сонин нь өөрийн гэсэн сурвалжлагчдаа Хүрээ, Ховд, Улиастайд томилолтоор явуулдаг байжээ⁴.

Тус сонинд “Засгийн газрын албан мэдээ”, “Цахилгаан мэдээний төвөөс уламжилсан гадаад мэдээ”, “Дорнод

хязгаарын байдал ба орон нутгийн сонсгол”, “Дорнод хязгаарын хөрш орны мэдээ”, “Элдэв сонин хачин”, “Зарлал мэдээ”, “Сонин сэтгүүлийн хуудсанд” гэх долоон булантай. “Засгийн газрын албан мэдээ” буланд дотоод гадаад байдлын тухай хааны зарлиг ба Хаант Оросын засгийн газрын шийдвэрийг нийтэлдэг байв. “Цахилгаан мэдээний төвөөс уламжилсан гадаад мэдээ”-д голдуу Лондон, Парис, Берлин, Нью-Йорк зэрэг гадаад орнуудын мэдээ, гадаад улсын тэргүүн нарын төрийн айлчлал, засаг төрийн шийдвэр, шашин зан үйл зэргийг мэдээлдэг байв. “Дорнод хязгаарын байдал ба орон нутгийн сонсгол”-д Оросын Чита, Ү-Да, Эрхүү зэрэг дорнод хязгаарын хот ба орнуудын байдал ахуйг тусгаж байв. “Дорнод хязгаарын хөрш орны мэдээ”-д голдуу Монголын тухай мэдээлдэг байжээ. Ихэнх нүүрийг Манж Чингийн дарлал болоод Монгол орны хоцронгүй байдлыг илүүтэйгээр бичдэг байжээ. “Элдэв сонин зүйл”-д голдуу дэлхийн шинжлэх ухааны шинэ үзэл суртал ба ололтыг мэдээлж байв. “Зарлал мэдээ” буланд худалдаа арилжааны тухай зар, цаг уурын мэдээ, шинэ номын мэдээ, банк ба мөнгөн гүйлгээний тухай нийтлэдэг байжээ. “Сонин сэтгүүлийн хуудас”-д нөлөө ихтэй сонинуудад нийтлэгдсэн материалуудыг шилжүүлэн гаргадаг байсан юм.

“Монголын сонин бичиг”-ийг Оросын Дүн чинг төмөр замын товчоо 1909 оны тавдугаар сарын 6-нд Харбинд монгол хорголжин бараар хэвлэж эхэлжээ. 1918 оны сүүлч буюу 1919 оны эхэн хүртэл хэвлэгдээд Оросын хувьсгал эхлэж, Харбинд байсан оросууд түшиггүй болсноос хэвлэл зогссон бололтой. Нийт 300-гаад дугаар хэвлэгджээ. Сонин дээр Өвөр Монголын Содном, Алмааз-Очир, Лифенган,

Эрдэнэ-Буян, Халх Монгол буюу Буриадын Цэдэн-Иш, Бадрахбаатар, Бодоо, Б.Намсрай, Д.Намсрай, Далхаа-Жав нар урьд хожид найруулагч, сурвалжлагчаар ажиллаж байжээ. Сонин Ар Монголын их хүрээ Улиастай, Ховд, Хайлаар, Бээжин зэрэг газарт сурвалжлагч томилж суулгадаг бөгөөд цахилгаан мэдээний аргаар сонины мэдээ дамжуулдаг байсан юм⁵.

“Монголын сонин бичиг” нь сониныхоо тэргүүн хуудсанд байнга гаргадаг тэргүүн шүүмжээс гадна “Да хүрээний сонин мэдээ”, “Монгол газрын сонсгол”, “Хятадад”, “Орост”, “Манжуурт”, “Гадаад олон улсын сонсгол”, “Цахилгаан мэдээ” гэх мэтийн байнгын булантай байж, дараагаар нь “Чухал сонсгол”, “Оросын эртний түүхэн товчоон”, “Ажил ахуйг залгуулах зүйл”, “Европын их байлдааны сонсгол” зэрэг булангуудыг нэмжээ.

2. Монголчуудын эрхэлсэн анхдагч сонин “Нялх сэтгүүл”

1905 оны 10 дугаар сараас өмнө Харчин баруун хошууны Жүнь Ван Гүнсэн-Норов⁶ ардын байдлыг дээшээ мэдэгдэж, хошууныхаа зардлыг ардад уламжлахын төлөө “Гарагийн албан сэтгүүл” гэх сониныг чулуун дармалаар хэвлэж байжээ⁷. Тэр жилийн өвөл Гүнсэн-Норов ардын мэдлийг нээж шинэ засгийг суртачлахын тулд төвийг эрхэмлэх сургуулийн хүрээнд нэгэн сонины газар гаргаж чулуун бараар хоёр өдөрт нэг дугаар гаргадаг томхон нүүртэй сонин хэвлэжээ. Энэ сониноо нь “Нялх сэтгүүл” хэмээн нэрийдэж, төвийг эрхэмлэх сургуулийн танхимын багш, сурагчдаас эх бичиг ирүүлэх шаардлага тавьсан бөгөөд гадаад дотоодын чухал мэдээ, шинжлэх ухааны мэдлэг, монгол хошуудын ахуй байдал, цагийн байдлын тухай охор

шүүмжийг нийтэлдэг байжээ. Сонин түгээгчээс хүн ам олонтой суурин газраар хүрч төлбөргүйгээр тараан өгдөг байв⁸. “Гарагийн албан сэтгүүл”-ийн сонин эрхлэх зорилт ба сонины агууллагад засвар хийн “Нялх сэтгүүл” хэмээн өөрчлөн гаргасан байж магадгүй хэмээн зарим судлаачид үздэг. “Нялх сэтгүүл” бол монголчуудын өөрийн эрхлэн гаргасан Монголын анхны сонин юм. “Нялх сэтгүүл” гэсэн энэ нэрийдэл бол “Инг Бао” гэсэн хятад нэрийдлийг шууд орчуулж авсан нэр юм. Учир нь бидний жишээ болгосон “Нялх сэтгүүл”-ийн тухай материалууд хятад хэл дээр байж, монгол хэлээр чухам юу гэж нэрлэж байсан талаар тодорхой тэмдэг хараахан олдоогүй юм. Монгол хэлээр тогтмол хэвлэлийг нэрлэхдээ “Бодрол”, “Дармал”, “Сэтгүүл”, “Сонин” гэх зэргээр нэрлэж байсан бөгөөд “Сэтгүүл” гэх үг нь тухайн үеэс Хятадын “Бао” гэдэг үгтэй нийцүүлэн адил утгаар хэрэглэж байсан юм. Энэ утгаас “Инг Бао”-г “Нялх сэтгүүл” гэж орчуулахаас өөр аргагүй байжээ.

3. Манж Чингийн засгийн газрын эрхэлсэн анхдагч монгол сэтгүүл

“Монгол үгийн бодрол” сэтгүүлийг 1908 оны дөрөвдүгээр сарын 15-нд Гериний Монголын явдлыг шийдэх газраас монгол болон хятадаар чулуун дармалын аргаар сар тутамд хэвлэж байв. Нийслэлийн Ченг-И, Гериний Чинг-Шан, Мөгдөний Лү Хуая Чин нар сэтгүүлийн тушаалыг баригч түшмэлээр, Үй Чин, Гөө Шү Чанг, Анг Мин нар урьд хожид журмаар туслагч түшмэдийн хувьд хятад үсгийн найруулагчаар, Жөн Шянь Чоу, Ван Зай Фөн нар хятад үсэг бичигчээр, Маа Жень Шунь зураг зураачаар ажиллаж байжээ. Монгол үсэг бичигчээр Соромбо, Ихт Чүнь, Юун Чөн, Шян Юнь, Фу Тай, Их Тунгаа нар ажиллаж байв⁹.

Сэтгүүлд “Дээд зарлиг”, “Богдын зарлигийг сэнхрүүлэн бадруулсан нь”, “Хэлэлцсэн зүйл”, “Цагийн хэргийн чухал сонсгол”, “Гүйхэн ойр сургаалийн хэлэлцсэн ану”, “Элдэв юмны зүйл айлтгасан учир”, “Илүүц зүйл”, “Зээлийн юмны үнэ”, “Нэмсэн жороо” хэмээх байнгын булантай байж, аравдугаар дугаараас хойш “Эртний явдал” хэмээх булан нэмжээ. “Дээд зарлиг”-т хааны зарлигийг тэмлэглэн бичиж, Манж Чин улсын хаан монголчуудыг ивээн соёрхсон “Эрдэм сэтгэл”-ийг сурталчилсан байдаг. “Богдын зарлигийг сэнхрүүлэн бадруулсан ану” буланд бичгийн сургаалтан Богд мэргэдийн сургаалийг цувруулан нийтэлдэг. “Хэлэлцсэн зүйл”-д нийгмийн асуудлуудыг шүүмжлэн өгүүлдэг. “Цагийн хэргийн чухал сонсгол”-д Монгол орны улс төр, аж ахуй, сурган хүмүүжүүлэх ухаан, шашин шүтлэгийн тухай сонин мэдээг гаргасан байдаг. Нийтэлсэн сонин, мэдээллийн олонхыг нь хаан төрийн “эрдэм чадал” Орос, Японы Монгол орныг эрхшээлдээ байлгах гэсэн зэрлэг “санаа”-г илчлэн гаргасан нь гайхамшигтай байна. “Гүйхэн ойр сургаалийг хэлэлцсэн ану”-д газар зүй тооны ухаан, тариалангийн ухааны мэдлэгийн зохиолыг нийтэлж, шинжлэх ухааны мэдлэгийг уламжилжээ. “Элдэв юмны зүйл”-д голдуу ёгт үлгэрүүд нийтлэгдэж сэрэмжлэн хичээх, бүгдээр нэгдэх, мууг нь хаяж сайныг сурах, ховдог санаа ба атгаг сэтгэлийг тэвчих, номхон даруу байх зэрэг ёс учрыг ухуулахын дагуу Орос, Японы атгаг санаа, арга ухааныг сэрэмжлэн хичээхийг сануулжээ. “Айлтгасан учир”-д голдуу Чин гүрний “Шинэ засаг”-ийн бодлого хэрэгжүүлэлтийн тухай олон яам айлтгал, нугалбар, эвхмэлүүдийг нийтэлжээ. “Зээлийн юмны үнэ”-д Герин мужийн сар болгоны “Мөнгө амны

цагийн үнийн хуудас”-ийг нийтэлж байжээ. “Эртний явдал” буланд Монголын мандсан түүхийг Чингисийн дээдэс Бодончироос эхлэж үргэлжлүүлэн хэвлэж, “Түмэн улсын ойрхи ертөнцийн явдал”-д гадаад улсуудын ойрын түүхэн хэрэг учруудыг танилцуулжээ. “Нэмсэн жороо”-д сэнхрүүлэлтийн шинжтэй үлгэрүүдэд зурмал зураг хавсран нийтэлж, гүн ухаалаг ёс учрыг амьд дүрслэлээр илтгэсэн бөгөөд Орос, Японоос сэргийлэх хэрэгтэй гэдэг ёсыг ёгт үлгэрээр дамжуулан дамаар сэрэмжлүүлж байв. “Илүүц зүйл”-д хууль цааз тогтоох ба газар орон өөртөө засах, иргэдийн эрхийн тухай асуудлуудыг тайлбарлажээ.

Гурав. Сонин сэтгүүлийн үндсэн зорилт, суртал ухуулга

“Дорнод хязгаарын амьдрал” сониныг хаант Оросоос Монгол орны Манж Чин улсаас салгаж Орост нэгтгэх улс төрийн бодлогыг идэвхжүүлэх бодлогоор эрхэлсэн болохоор хаант Оросын эзэнт ёсыг магтсан, хаант засгийн бодлогыг сурталчилсан, оросуудын ашиг сонирхлыг илэрхийлсэн, Манж Хятадын дарлалыг илчилсэн материал буюу нийтлэлийг олонд харагдахын хамт ийнхүү өнгө аястай нийтлэлүүд түлхүү гарч байжээ. Гэвч сониныг биечлэн хийж байгаа найруулагч нар нь ардчилсан үзэлтэй сэхээтнүүд байсан болохоор сонинд Буриад болон Монгол орны ядуу, хоцронгүй байдлыг тусгасан, монголчуудын мэдлэг ухамсрыг дээшлүүлэхийг зорьсон, ардчилсан үзэл санааг ухуулсан, ард иргэдийн эрхийг хамгаалсан агуулга бүхий нийтлэл ихэнх тоог эзлэж дэвшилттэй байсныг энд дурдах ёстой.

“Монголын сонин бичиг” хэвлэл эрхэлсэн зорилтоо тодорхойлохдоо “Манай сонин бичиг гаргасан уг санаа бол монголчуудын оюун санааг тэлж түргэн хугацаанд өөрийн улс төрийг өршөөн хэмжээд хууль байгууллага лугаа нийцүүлж басхүү олон монгол даруй баян чийрэг болохыг үнэхээр хүсч эрмэлзэнэ”¹⁰ гэжээ. Гэвч “Монголын сонин бичиг”-ийг хаант Оросын Дүн Чинг төмөр замын төвчоо өөрөөр хэлбэл хаант Оросын засгийн газар хөрөнгө оруулсны хувьд сонин эрхэлсэн зорилго нь зөвхөн “Монголын ухаан мэдлэгийг түргэн нээгдүүлэх”, “Монголыг баян чинээлэг болгохыг хүсэх” явдал яасан ч биш. Харин үүгээр шалтгаалан ухаант Оросын алс Дорнодыг эзэмдэх шунахай санаанд яриа хэлэлцээр зохиож суртал ухуулга хийхийн хамт хаант Оросын ашиг орлогыг батлаж тэдний Монгол орон дахь нөлөөг өргөтгөх, өөрөөр хэлбэл хаант Оросын бодлогыг сурталчлах бол тус сонины хамгийн үндсэн зорилт болно гэдгийг бид сонины нийтлэлүүдээс тодорхой харж болно. Иймэрхүү цаг үед “Монголын сонин бичиг” дараах хоёр зүйлийн суртал ухуулгыг голчлон хийжээ.

1.Тус сонины эхний дугааруудад Орос болон Хятад улсад үүссэн хөрөнгөтөн ангийн ардчилсан хувьсгалийн тухай хүч тавин мэдээлдэг байсан бөгөөд байнга өгүүлэл шүүмж нийтлэж хөрөнгөтөн ардчилал, түүний ёс суртахуун, нийгмийн байгууллага нь олон талаар давуу талтай байхыг сайшаан сурталчилж байв. “Монголын сонин бичиг” Орос болон Хятад улсад өрнөсөн хөрөнгөтөн ангийн ардчилсан хувьсгалийн үйл явдал ба утга агуулгыг идэвхтэй сурталчлан ухуулга хийж байсны учир бол энэхүү хөдөлгөөний

“эрх тэгш ардчилалтай байх, дарлал мөлжлөгийг эсэргүүцэх, тусгаар тогтнолыг биелүүлэх” ардчилалын үзэл санаа нь ар, өвөр Монголд үүссэн Манжийн ноёрхлыг эсэргүүцэж үндэстний тусгаар тогтнолоо тэмцэн олох хөдөлгөөний үзэл санааны бэлтгэл болсон байх юм.

2. “Монголын сонин бичиг” нь маш олон бодит хэрэг учрын мэдээллээр дамжуулан Манжийн ноёрхогчид, Бээжингийн засгийн газрын Монгол орны битүү түгжирмэл хоцронгуй байдалтай болгосон, монголчуудын эрх мэдлийг хасаж, газар орныг нь булаасан, монголчуудыг зөвхөн доромжилж байсныг бодитой баримтаар нотлон илчилж байжээ. Тэрчлэн Монголын тусгаар тогтнолын хөдөлгөөнийг ч өргөнөөр мэдээлэн дамжуулж байсан юм. Сонинд Монголын тусгаар тогтнолыг үл мэдсэн элдвээр дайрч байгаа байдалд чиглүүлж “Энэ удаа монгол хүн өөртөө эзэн болсон нь Хятад улс өөрөө нь аргагүй ёс алдсанаас болжээ”¹¹ гэж зааж гаргасны хамт Монгол улс “Тусгаар тогтносон”-ы дараа авсан улс орны бэхжилт хөгжилд ашигтай арга хэмжээг “Монголын сонин бичиг” цаг тухайд нь мэдээлэн дамжуулж байжээ. Эдгээр бүхэн нь ч хаант Оросын бодлоготой нийцэж байгаа юм.

“Нялх сэтгүүл” бол Манж Чин улсын ноёрхолд байсан монгол хушуунд хэвлэгдсэн анхны бөгөөд цорын ганц тогтмол хэвлэл мөн. Энэ сонин монгол хүн өөрийн зорилгоороо дур мэдэн эрхэлдэг хэвлэл байсан юм. Ялангуяа Гүнсэн-Норовын яриа илтгэл ба түүний хошуундаа хийсэн аль олон өөрчлөлтийн үйл ажиллагаагаас авч үзвэл тус сонин монгол ардын ухаан мэдлийг нээх, монголчуудаа соён гэгээрүүлж хүмүүжүүлэх ба монгол үндэстнээ

хөгжүүлэн мандуулах зорилтоор эрхэлснийг амархан ойлгож болно. Тус сонины уг эх одоо болтол олдоогүйгээс гадна түүх болгон хадгалах материал ч ховор байгаа юм. Энэ асуудлыг зөвхөн хойшдын судалгаа буюу хойчийн судлаачдад ч үүрэг болгон үлдээх хэрэг болжээ.

“Монгол үгийн бодрол” сэтгүүл эрхлэх зорилтынхоо тухай “Бид эдүгээ Мон-

гол үгийн бод-ролын нэгэн дэвтрийг шийдэн гаргаж үүний эцэст ямар учир гэмээнэ...Тийм нэгэн улс Манжийн газраа санаа сэтгэлд нийцэхгүй хойш буцаж баруун хойш зүг ирээд эд ашиг ба тустай явдлыг ярьж, бидний Монголын энэ мэт сайн газар тэднээ нэгэнт санаандаа бодчихуй... Бусад хүн нар танай лугаа янаглан найртай болье хэмээн ойртож, бас ч хэлэх ану бид



“Нялх сэтгүүл” бол Манж Чин улсын ноёрхолд байсан монгол хушуунд хэвлэгдсэн анхны бөгөөд цорын ганц тогтмол хэвлэл мөн. Энэ сонин монгол хүн өөрийн зорилгоороо дур мэдэн эрхэлдэг хэвлэл байсан юм. Ялангуяа Гүнсэн-Норовын яриа илтгэл ба түүний хошуундаа хийсэн аль олон өөрчлөлтийн үйл ажиллагаагаас авч үзвэл тус сонин монгол ардын ухаан мэдлийг нээх, монголчуудаа соён гэгээрүүлж хүмүүжүүлэх ба монгол үндэстнээ хөгжүүлэн мандуулах зорилтоор эрхэлснийг амархан ойлгож болно. Тус сонины уг эх одоо болтол олдоогүйгээс гадна түүх болгон хадгалах материал ч ховор байгаа юм



бичиг суртал цөм адил бөгөөд бас ч нэгэн угсаа болмой хэмээн гаднаас үзвээс янаг найртай адил, түүнд тодорван санасан ану манай Монгол хүмүүсийг боолчид болгон хэрэглэсүй хэмээн санамой... Үүнийг бид бас мэдэхгүй... Тэр гадаад улсын тэмцэлдэх хүчнийг үзвээс улам идэрхэгээр шахамдуулан байхын хэр-хэвчээр тэдний дураар манай монгол хүнийг доромжлон болох буюу, харин ч нэгэн сайн аргыг үүсгэж олон бүхнээр тодорхойлон мэдүүлвээс зохих атлаа... Энэ бодролыг ухуулан гаргаваас... Хүн хүн бас ч энэ учрыг мэдэж болмой...”¹² гэжээ. Үүнээс Чин улсын засгийн талаас монгол ардын ухаан мэдлийг “дэлгэрүүлэн” Орос ба Японы монголчуудыг өдөөн татаж Монгол орныг эрхшээх гэсэн “санаа” –г илчилж байгаад Манж Чин улсын умард халхавч болсон Монгол орон дахь Орос, Японы нөлөөний өргөжилтийг хориглох зорилтоор тус сэтгүүлийг эрхэлж байсныг тодорхой харах болно.

Тус сэтгүүл Герин мужийн Монголын явдлыг шийтгэх газраас эрхэлсэн сэтгүүл болсны хувьд тухайн үеийн төр засаг болох Манж Чин улсын санаа зорилтыг дараах хоёр талаар сурталчилж байсан юм.

1. Сэтгүүлийн эл булан дахь нийтлэлийг ажиглавал хааны “Эрдэм сэтгэл”-ийг ухуулан дэлгэрүүлэх ба Орос, Японы Монгол орныг эзэгнэх санааг илчлэхийг төрөл бүлийн буланд нийтлэн шингээж үүгээр дамжуулж Орос, Японы Монгол орон дахь нөлөөний өргөжилтийг хориглож, Хятад улсын Монгол орон дахь эрх мэдлийг батлах зорилт тавьсан нь илэрхий байна.

2. Сэтгүүлд илэрсэн шарын шашныг хязгаарлах, соёл сурган хүмүүжүүлэх ухааныг хөгжүүлэх, зам засч уурхай

нээж аж үйлдвэр эрхлэх, атар газрыг ашиглаж тариаланг хөгжүүлэх тухай нийтлэлүүд нь Монгол оронд хэрэгжүүлэн хийж байсан Чин гүрний төрийн бодлого чиглэлийг сурталчилсан шинэ засгийг сурталчилж Чин улсын санаа зорилтыг идэвхтэй тусгаж байсныг харуулж байна.

Дүгнэлт

Найдвартай баримт бүхий хамгийн анхны монгол сонин бол 1895 онд Оросын Чита хотод хэвлэгдэж байсан “Дорнод хязгаарын амьдрал” сонин болно. Харчин баруун хушууны засагт Жүн Ван, Гүнсэн-Норовын 1905 онд эрхэлсэн “Нялх сэтгүүл” бол монголчууд өөртөө эрхэлсэн анхдагч сонин мөн. Энэ хоёр сонин хэвлэгдсэн явдал нь монгол сонин бий болсныг тунхаглаж монголчуудын сонин сэтгүүлийн үйлсийн хөшигийг ярсан байна.

19-р зуунаас хойш, хаант Орос Манж Чиний албадлагаар аль олон гэрээ буюу дүрэм тогтоохоор дамжин Монгол оронд эрх дураар худалдаа аралжаалах эрхийг олсон бөгөөд Хиагтаас Монгол орноор дамжин Бээжин хүрэх улаан өртөө хэрэгсэх эрхийг эзэмшиж, ар, өвөр Монгол ба ойрад Монгол зэрэг бүхий л Монгол орныг тэдний ганцаар эзэрхсэн гааль тушаахгүй арилжааны талбар болгон хувиргасан. Оросууд эдгээр ажиллагаатай хамтарч сонин сэтгүүл эрхлэн монголчуудыг өдөөн татахаар оролцож байсан юм.

Хаант Орос ба Японы түрэмгийллийн ажиллагаанд чиглүүлж Манж Чингийн засгийн газар ч сонин сэтгүүл эрхлэн харьчуудын Монгол хошуудын уурхай нээж, эх баялагийг тонож, монголчуудыг өдөөн татаж Манж Чингээс салган Монгол орныг эзэмдэх гэсэн зэрлэг санааг хүч тавин

илчлэхийн хамт хааны "Өршөөл журам"-ийг ухуулж, монголуудад "Улс гүрний бодлого"-ыг сурталчилж байв.

Манж Чин улсын засгийн газрын шинэ цэрэг боловсруулах, гаалийг нэмэгдүүлж гадаадын өрийг төлөн, цэргийн зардлыг аргацаах, худалдаа үйлдвэрлэлийг чөлөөтэй хөгжүүлж, шинэ маягийн сургууль байгуулахаар зорьсон. "Шинэ засаг"-ийн өөрчлөн шинжлэх үзэл урсгалын нөлөөллөөр сэхээрсэн Монгол Ван Гүн дээд давхаргад ч монгол ардын ухаан мэдлийг нээж үндэстнээ мандуулах дархан үйлсд зүтгэж сургууль байгуулан сонин сэтгүүл эрхэлсэн байна.

Монгол сонин сэтгүүлийг бол эл зүйлийн улс төрийн хүчин Монгол орныг булаалдах, монголчуудыг өдөөн татах буюу соён гэгээрүүлэх монголчуудын дунд суртал ухуулга хийх хуваарь эрхлэн гаргасан. Иймээс эдгээр сонин сэтгүүл бол улс төрийн шинжтэй.

Ишлэл

- ¹Тус өгүүлэл нь Хятад улсын 2019 оны нийгмийн шинжлэх ухааны төсөл "Орчин үеийн дундад улсын Монгол сонин сэтгүүл хийгээд яриа хэлэлцээрийн судлал" –ийн нэг хэсэг агуулга болно.
- ²Бадмаев (1851-1919) бол Орос нутагтай Агаа аймгийн Буриад монгол хүн болно. 1871 онд тэр Оросын Петербург их сургуулийн Дорнод хэлний салбарт орж, хятад, манж, монгол хэл сурсан бөгөөд төвд эмнэлэгт мэргэшсэн хүн байсан болохоор оросын цагаан хааны ордны эмч болж, Оросын хаанд ихэд таалагдсан шадар хүмүүсийн нэг байжээ. 1857-1893 он хүртэл хаант Оросын засгийн газарт алба гүйцэтгэж, 1919 онд Петербурgt таалал төгсчээ.
- ³Бадмаев хаант засгийн бодлогыг хэрэгжүүлэхийн тулд Сисиряскийн төмөр замаас Монгол орноор өнгөрөх төмөр зам тавьж Ланжөү хүргэхийн хамт Байшаль нуурын орчимд "Хувь хүний шинжтэй" худалдааны том төв байгуулж арилжаалах нэрээр Манж Чингийн хил

хязгаар орон ба дотор газарт хүрч хэвлэл мэдээллийг цуглуулан улмаар монголчуудыг өдөөн Оросод оруулах томхон төлөвлөгөө боловсруулжээ. Үүнийг "Бадмаевийн төлөвлөгөө" гэдэг.

- ⁴Сонин мэдээ хэвлэлийн Бодь найруулга комисс найруулав, Монгол судлалын нэвтэрхий толь, сонин мэдээ хэвлэлийн бодь, 372-373 дугаар нүүр, Өвөр Монголын ардын хэвлэлийн хороо, 2003 он.
- ⁵Сонин мэдээ хэвлэлийн Бодь найруулга комисс найруулав, Монгол судлалын нэвтэрхий толь, сонин мэдээ хэвлэлийн бодь, 372-373 дугаар нүүр, Өвөр Монголын ардын хэвлэлийн хороо, 2003 он.
- ⁶Гүнсээноров (1872-1930) Цустын чуулганы харчин баруун хошууны засаг Жүнь Ван. Тэрээр 1902-1904 оны хооронд урьд хожид 3 сургууль байгуулж хушууны Монгол хүүхдийг хүмүүжүүлсэн бөгөөд бас шилдэг сурагчийг сонгон Япон зэрэг газарт томилон суралцуулжээ. Гүнсээноров бол Монгол үндэстний орчин үеийн түүхэн дэхь гарамгай зүтгэлтэн мөн. 1913 онд Монгол Төвдийн хэрэг явдлыг шийтгэх яаманд ерөнхий шийтгэгчийн албыг 16 жил гүйцэтгэж, 1930 онд Бээжийнгийн ордондоо өөд болжээ.
- ⁷ 忒莫勒编著: 《内蒙古旧报刊考录》, 远方出版社, 2010年.
- ⁸ 吴恩和刑复礼: 贡桑诺尔布, 《内蒙古文史资料》第一辑, 第109页, 内蒙古人民出版社, 1986年.
- ⁹ "Монгол үгийн бодрол" 10 дугаараас 23 дугаар- 25 дугаар удаагийн дэвтрийн" Уул бодролын тушаалын захиргаа" –д
- ¹⁰ Г.Дэлэг "Монгол тогтмол хэвлэлийн түүхэн тэмдэглэл", Улсын хэвлэлийн хэрэг эрхлэх хороо, Улаанбаатар, 1965 он 38-р нүүр.
- ¹¹ Ломбын Норовсүрэн, Монголын сэтгүүл зүйн түүхэн тойм, Дээд дэвтэр, 57-р нүүр Өвөр Монголын ардын хэвлэлийн хороо, 2006 он.
- ¹² "Монгол үгийн бодрол", Бодролт төрийн 34-р он долоодугаар сарын 10 нд дахин дармал гаргасан, Нэгдүгээр удаагийн дэвтэр.

Ашигласан бүтээлийн жагсаалт

1. С.Жамбалдорж, "Монгол нууцын хэлхээ-3", Улаанбаатар, 1990 он

2. Г.Дэлэг, “Монгол тогтмол хэвлэлийн түүхэн тэмдэглэл”, Улсын хэвлэлийн хэрэг эрхлэх хороо, 1965 он
3. Ломбын Норовсүрэн, “Монголын сэтгүүл зүйн түүхэн тойм”, Тэргүүн дэвтэр, Өвөр Монголын ардын хэвлэлийн хороо, 2006 он
4. Нагуусайн хүү нарийн гол хүү Тэмгэтийн намтар, Өвөр Монголын шинжлэх ухаан техник мэргэжлийн хэвлэлийн хороо, 1989 он
5. Төгсцогт Ван Шиү Лан, “Монгол сонин сэтгүүлийн түүхэн тойм” Өвөр Монголын их сургуулийн хэвлэлийн хороо, 1999 он
6. Сонин мэдээ хэвлэлийн Бодь найруулах комисс найруулав. “Монгол судлалын нэвтэрхий толь сонин мэдээ хэвлэлийн бодь”, Өвөр Монголын ардын хэвлэлийн хороо
7. 忒莫勒编著：《内蒙古旧报刊考录》· 远方出版社· 2010年。
8. 白拉都格其、金海、赛航 撰写：《蒙古族通史》第五卷（上），内蒙古大学出版社，2002年。
9. 郝维民主编：《内蒙古近代简史》· 内蒙古大学出版社，1992年。
10. 丁淦林主编：《中国新闻事业史》· 高等教育出版社· 2002年。
11. “Монгол үгийн бодрол” нэг, хоёр, гурав, арван долоодугаар удаагийн дэвтэр.
12. 吴恩和 刑复礼：贡桑诺尔布·《内蒙古文史资料》第一辑·内蒙古人民出版社，1986年。
13. 谢缅尼科夫：在东亚的冒险—俄国兼并中国，西藏和蒙古，《内蒙古近代史译丛》第一辑，内蒙古人民出版社，1986年。
14. 忒莫勒：《蒙话报》研究，《蒙古学信》，2001年第3期。
15. フフバートル：漢語の影響下におけるモンゴル語近代語彙の形成—中国領内のモンゴル語定期刊行物発達史に沿って，博士学位論本 1997.10.30。

Агуулгын товч

Тус өгүүлэл монгол сонин сэтгүүлийн үүссэн түүхэн ахуй байдлыг товчлон өгүүлсэн суурин дээр Манж Чин улсын сүүлч үед гарч байсан “Дорнод хязгаарын амьдрал”, “Монголын сонин бичиг”, “Нялх сэтгүүл”, “Монгол үгийн бодрол”-ын үндсэн байдлыг танилцуулж түүний агуулга, хэлбэр, зорилтыг задлан өгүүлэхээр дамжин монгол сонин сэтгүүл бол тогтсон улс төр, аж ахуй сурган хүмүүжүүлэх болон техник мэргэжлийн түүхэн нөхцөлд ялангуяа улс үндэстэн доройтон мөхөх аюул түгшүүрт ахуй байдалд эл зүйлийн улс төрийн хүчин Монгол орныг булаалдах, нийгмийн асуудлыг ярилцах үзэл суртлын хувиар мэндэлсэн юм гэж дүгнэжээ.